

**Цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүр бүхий аппарат, төхөөрөмжтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт**

Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл хүсэгч нь Цөмийн энергийн тухай хуулийн 19.4-т заасны дагуу дараах материалыг бүрдүүлнэ.

№	БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГҮҮД
1.	Тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг
2.	Өргөдлийн маягт /МХЕГ-ийн вэб сайтаас өргөдлийн маягтыг татаж, маягтын дагуу бүрэн бөглөх/
3.	Тусгай зөвшөөрөл хүсэгчийн аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; /эмнэлэг бол эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хуулбарыг хамт ирүүлэх/
4.	Эрхлэх үйл ажиллагааны зорилго, төрөл, үндсэн чиглэл, техник, эдийн засгийн үндэслэл (үүнд, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажилладаг талаар дэлгэрэнгүй бичнэ. МХЕГ, НМХГ-аас цацрагийн хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын тэмдэглэлийн хуулбар, түүнчлэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан тухай тайлан)
5.	Мэргэжлийн боловсон хүчний танилцуулга (Цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүр бүхий аппараттай ажиллах техникч), дотоод хяналтын ажилтан болон цацрагтай ажиллагчийн (техникчийн мэргэшлийн бэлтгэл, сургалтын гэрчилгээ;
6.	Цацрагийн аюулгүйн дотоод дүрэм (Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагчаар хянуулж батлуулсан байх);
7.	Цацрагийн аюулгүйн хөтөлбөр /ажлын байрны хяналт/, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө (Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагчаар хянуулж батлуулсан байх);
8.	Цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө (Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагчаар хянуулж батлуулсан байх);
9.	Дотоодын хяналт тавих алба, эсхүл хариуцсан ажилтныг томилсон тухай шийдвэр; (Байгууллагын дарга, захирлын тушаалаар цацрагийн хамгааллын ажилтанг томилсон байх)
10.	Ослын уршгийг арилгахад шаардлагатай нөөц боломж, хүч хэрэгслийн тухай танилцуулга (үүнд, цацрагаас хамгаалах хувийн хамгаалах хэрэгслийн зургийг дарж хүснэгтэд оруулан, нэр, тоо ширхэгийн хамт оруулна. Ингэхдээ интернетээс зураг татаж оруулахгүй, зөвхөн тухайн байгууллагад ашиглагдаж байгаа хамгаалах хэрэгслийн зургийг оруулна);
11.	Хяналтын багаж, түүний үзүүлэлт, баталгаажилтын гэрчилгээ;
12.	Цацрагийн үүсгүүрийн үйлдвэрийн гэрчилгээ, үзүүлэлтүүд, чанарын гэрчилгээ
13.	Өөр байгууллагын байранд үйл ажиллагаа явуулдаг бол түрээсийн гэрээ
14.	Импортын зөвшөөрлийн хуулбар

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР